

# 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН





2023 онд Монгол улсын **эдийн засгийн өсөлт 7.0 хувьд хүрч сайжрав** /2022 онд 5.0 хувь/



2023 оны эцэст **инфляц 7.9 хувь** болж буурлаа. /2022 онд 13.2 хувь/



Монголбанк 2023 онд **бодлогыг хүүг 13.0 хувьд** хэвээр хадгалав.



Гадаад валютын нөөц нэмэгдэж 4.9 тэрбум ам.долларт хүрснээр төгрөгийн ам.доллартой харьцах ханш харьцангуй тогтвортой байж өмнөх оноос бага зэрэг чангарав. **Ам.долларын ханш** 2022 оны эцэст 3,444.6 байсан бол 2023 оны эцэст **3,410.7 төгрөгт** хүрэв.

**IPO**

Банкны тухай хуулийн шинэчлэлттэй холбоотой 2023 онд **системийн 3 банк IPO гаргаж 302.6 тэрбум төгрөгийн** хөрөнгө татан төвлөрүүлснээр системийн нөлөө бүхий 5 банк /+Богд банк/ нээлттэй хувьцаат компани болов.


## ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2023 оны эцсээр эдийн засгийн өсөлт 7.0 хувийн өсөлттэй гарав. Үүний 2.6 хувийг уул уурхай, олборлолтын салбар, 2.1 хувийг үйлчилгээ, худалдааны салбар, 1.8 хувийг Тээвэр ба агуулахын салбар бүрдүүлсэн. Хөдөө аж ахуйн салбараас бусад салбар өсөлт үзүүлсэн байна.

## МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ БА ИНФЛЯЦИ



Эх сурвалж: Монголбанк


Монгол Банкнаас инфляцыг бууруулах болон төгрөгийн үнэ цэнийг хадгалах зорилгоор бодлогын хүүг 2023 оны турш өндөр хэвээр буюу 13 хувьд хадгалсан ба улсын жилийн инфляц өмнөх оны 13.2 хувиас буурч 7.9 хувьд хүрлээ. 2023 оны эцэст мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 26.8 хувьтай гарлаа.

# ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ 2023

Нийт хөрөнгийн зах зээлд эзлэх хувь:  
19.4%-с 20.1%-д хүрч өсөв



Нийт зээлийн зах зээлд эзлэх хувь: 17.3%-с 17.5%-д хүрч өсөв



Харилцагчийн эх үүсвэрийн зах зээлд эзлэх хувь: 18.4%-с 20.0%-д хүрч өсөв

Арилжааны хэмжээ  
**29%**

Онлайн худалдааны гүйлгээний тоо, дүн  
**69%, 45%**

Q3'2023 байдлаар

Кастодиан банк  
**45%**




Эх сурвалж: Монголбанкны статистик ашиглав

| Санхүүгийн гол үзүүлэлтүүд (IFRS)                | 2019  | 2020  | 2021   | 2022  | 2023           | Өөрчлөлт |       |
|--|-------|-------|--------|-------|----------------|----------|-------|
|  |       |       |        |       |                | Дүн      | %     |
| <b>Балансын үзүүлэлтүүд (тэрбум ₮)</b>           |       |       |        |       |                |          |       |
| Нийт актив                                       | 6,643 | 7,278 | 7,994  | 8,985 | <b>11,628</b>  | 2,643    | 29%   |
| Харилцах, хадгаламж                              | 4,901 | 5,286 | 5,464  | 5,743 | <b>8,037</b>   | 2,293    | 40%   |
| Цэвэр зээл                                       | 3,307 | 3,031 | 3,339  | 3,698 | <b>4,712</b>   | 1,014    | 27%   |
| Нийт өөрийн хөрөнгө                              | 635   | 632   | 659    | 862   | <b>1,071</b>   | 209      | 24%   |
| <b>Орлогын тайлангийн үзүүлэлтүүд (тэрбум ₮)</b> |       |       |        |       |                |          |       |
| Цэвэр хүүгийн орлого                             | 211.9 | 204.4 | 282.0  | 385.6 | <b>477.3</b>   | 91.7     | 24%   |
| Цэвэр хүүгийн бус орлого                         | 81.0  | 82.5  | 48.6   | 141.7 | <b>(23.5)</b>  | (165.2)  | -117% |
| Своп-н нөлөө                                     | 15.0  | 14.5  | (21.8) | 34.7  | <b>(133.8)</b> | (168.5)  | -485% |
| Үйл ажиллагааны орлого                           | 292.9 | 286.9 | 330.5  | 527.2 | <b>453.8</b>   | (73.5)   | -14%  |
| Үйл ажиллагааны зардал                           | 122.0 | 121.0 | 137.1  | 175.3 | <b>200.2</b>   | 24.8     | 14%   |
| Үйл ажиллагааны ашиг                             | 170.9 | 165.9 | 193.4  | 351.9 | <b>253.6</b>   | (98.3)   | -28%  |
| Үйл ажиллагааны ашиг /свопын нөлөөгүй/           | 155.9 | 151.4 | 215.2  | 317.2 | <b>387.4</b>   | 70.2     | 22%   |
| Сан, үнэлгээний зардал                           | 146.0 | 143.4 | 140.8  | 158.1 | <b>(12.4)</b>  | (170.5)  |       |
| Татварын өмнөх ашиг                              | 24.9  | 22.5  | 52.6   | 193.8 | <b>266.0</b>   | 72.2     | 37%   |
| Цэвэр ашиг                                       | 16.3  | 10.4  | 25.9   | 116.5 | <b>209.2</b>   | 92.7     | 80%   |
| <b>Зохистой харьцааны үзүүлэлтүүд*</b>           |       |       |        |       |                |          |       |
| Өөрийн хөрөнгийн хүрэлцээ >12%                   | 13.5% | 14.2% | 13.3%  | 17.6% | <b>15.9%</b>   |          |       |
| 1-р зэрэглэлийн ӨХ хүрэлцээ >9% (нөөц 4%)        | 9.0%  | 13.8% | 13.0%  | 17.6% | <b>15.9%</b>   |          |       |
| ТТГЧ-н харьцаа >25%                              | 32.6% | 40.2% | 41.3%  | 36.3% | <b>38.3%</b>   |          |       |


\*Монголбанкны тайлангаар

## БАЛАНС (ТЭРБУМ ₮)

### Нийт зээл (тэрбум₮)




### Эх үүсвэр (тэрбум₮)




## БҮТЭЦ (%)


### Нийт зээл (%)



### Эх үүсвэр (%)




## НИЙТ АКТИВ (ТЭРБУМ ₮)



Нийт актив **29.4 хувиар буюу 2.6 их наяд төгрөгөөр өсөж** 11.6 их наяд төгрөгт хүрэв.

Өрсөлдөгч банкуудаас хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэнээр, **зах зээлд эзлэх хувь 19.4%-с 20.1% болж өслөө** /МБ-ны тайлангаар/.

## ӨӨРИЙН ХӨРӨНГӨ (ТЭРБУМ ₮)




Голомт банк 2023 онд 209.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, нийт өөрийн хөрөнгө 1.1 их наяд төгрөгт хүрлээ.

2023 оны 4-р сард банк 2022 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 50 төгрөг буюу нийт 40.4 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараав.

- Банк 2024 онд 2023 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 90 төгрөг буюу нийт 72.8 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаар зарлаад байна.

## ХАРИЛЦАГЧААС ТАТСАН ЭХ ҮҮСВЭР (ТЭРБУМ ₮)




Харилцагчийн эх үүсвэр **39.9 хувиар өсөж** 8 их наяд төгрөгт хүрлээ.

Нийт өсөлтийн 80%-г байгууллагаас татсан эх үүсвэр, 20%-г иргэдээс татсан эх үүсвэр эзэлж байна.

**Зах зээлд эзлэх хувь 18.4%-с 20.0% болж өсөв.**

## НИЙТ ЗЭЭЛ (ТЭРБУМ ₮)




Нийт зээл **25.2 хувиар өсөж** 4.9 их наяд төгрөгт хүрэв.

Нийт өсөлтийн 50%-г ритэйл сегментэд олгосон зээл эзэлж байна

**Зах зээлд эзлэх хувь 17.3%-с 17.5% болж өсөв.**




## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ –СВОП НӨЛӨӨГҮЙГЭЭР (ТЭРБУМ ₮)



Сан, үнэлгээний зардлын өмнөх Үйл ажиллагааны ашиг (свопын нөлөөгүйгээр) 387 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос **22.1 хувиар өсөв**.


## ЦЭВЭР АШИГ (ТЭРБУМ ₮)




Татварын дараах цэвэр ашиг **түүхэн дээд хэмжээнд** буюу **209.2 тэрбум төгрөгт** хүрэв.

## ГОЛ ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД


### Цэвэр хүүгийн ахиуц (%)




### Зардал орлогын харьцаа (%)



### Чанаргүй зээлийн харьцаа (%)\*




### Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж (%)




\*Монголбанкны тайлангаар

## ГОЛ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД

**Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа (%) \***



**ТТГЧ-н харьцаа (%) \***



| Үнийн харьцаа үзүүлэлт            | 2022        | 2023        |
|-----------------------------------|-------------|-------------|
| <b>BPS</b> (Book value per share) | 1,039.9     | 1,301.2     |
| <b>EPS**</b> (Earnings per share) | 163.7       | 258.7       |
| <b>PBR</b> (Price to BPS ratio)   | 1.2         | 0.7         |
| <b>PER</b> (Price to EPS ratio)   | 7.8         | 3.5         |
| Зах зээлийн үнэ-оны эцэст         | 1,274.00    | 906.74      |
| Нийт хувьцааны тоо                | 808,657,306 | 808,657,306 |

\*\*Дундаж хувьцааны тоо ашиглаж тооцов

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа, зээлийн төвлөрөл, төлбөрийн чадвар, гадаад валютын эрсдэлтэй холбоотой Монголбанкны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллалаа.

2023 оны эцсээр, банкны нэгж хувьцаанд ногдох ашиг 58%-р өсөж 258.7 төгрөгт хүрлээ.

\*Монголбанкны тайлангаар


## ИРГЭДИЙН ЗЭЭЛ

**₮2.2 их наяд**


YTD %: +28%



Зах зээлд эзлэх %



Голомтын зээлд эзлэх %




## ИРГЭДИЙН ЭХ ҮҮСВЭР

**₮3.5 их наяд**


YTD %: +15%



Зах зээлд эзлэх %



Голомтын депозитод эзлэх %




## АЯН ХӨТӨЛБӨРҮҮД

- УБ хот болон орон нутгийн нийт 19 төрөх эмнэлгүүдтэй хамтран ажиллаж, шинээр төрж буй үрсийг Голомт банкны харилцагчаа болгох **“NEW BORN II”** аяныг хэрэгжүүллээ. Аяны үр дүнд **3,000 гаруй ээжийг баярлуулж** 1,300 шинэ харилцагчийн **1,700** бүтээгдэхүүний борлуулалт хийлээ.
- Шинэ үеийн хүүхэд залуусыг Голомт банкны ирээдүйн үр ашигтай харилцагч болгох, одоогоос тэдэнд банкны үйлчилгээг шинэлэг байдлаар хүргэж таниулах **“GENZ LOYALTY”** урамшуулалт хөтөлбөрийг 2 дах жилдээ амжилттай хэрэгжүүллээ. Энэхүү аянд 7-25 насны **69,000 харилцагч** хамрагдлаа.
- Голомт банкны нийт харилцагчдыг идэвхжүүлэх, үнэ цэнтэй лоял харилцагчдыг нэмэгдүүлэх **“BIG LOYALTY”** урамшуулалт хөтөлбөрийг 2 дах жилдээ амжилттай хэрэгжүүллээ. Нийт **930,000 харилцагч** хамрагдаж лоялти оноо, түүнийг дагасан урамшуулалд идэвхтэй хамрагдлаа.



## ДИЖИТАЛ СУВГИЙН ШИНЭ БОЛОМЖУУД

- **SocialPay 3.0 шинэчилсэн** хувилбарыг зах зээлд нэвтрүүлэв.
- Монгол улсын банк санхүүгийн салбарт хамгийн **анхны виртуал кредит картыг** гаргалаа.
- Дижитал сувгуудаар **пос барьцаалсан зээл, тэтгэврийн зээл, дижитал зээлийн** үйлчилгээг хурдан шуурхай авах боломжийг нэмлээ.
- Төрийн банк болон Капитрон банктай хамтран ажиллаж **АТМ/СДМ-ын шимтгэлийг буурууллаа.**
- Шангри-ла худалдааны төвд **Wechat болон Alipay төлбөрт хүлээн авах** үйлчилгээг нэвтрүүлэв.
- **Гар утасны NFC технологийг** ашиглан гар утсаараа карт төлбөрт хүлээн авах цоо **шинэ Софт Пос үйлчилгээг** нэвтрүүлэв.
- Банкны карт, дансны үйлчилгээ болон Төрийн үйлчилгээг багтаасан **Смарт киоск төхөөрөмжийг** зах зээлд нэвтрүүлэв.
- **Байгууллагад зориулсан тоон гарын үсгийг** Corporate Gateway үйлчилгээнд нэвтрүүлэв.
- **Иргэний интернэт банканд тоон гарын үсэг** нэвтрүүлэв.
- **Ко-брэнд карт:** Централ Экспресс CU-тэй хамтран “CU Виртуал кредит карт”, ШУТИС-тай хамтран “All in one” картыг гаргалаа.



## ДИЖИТАЛ АРГА ХЭМЖЭЭ

- Дархан, Дорнод, Ховд, Баянхонгор аймгуудад “Нээлттэй ирээдүй” арга хэмжээг зохион байгууллаа.
- “ICT EXPO” арга хэмжээний зүгээс Голомт банкны дижитал үйлчилгээ, шинэ шийдлүүдийг “ШИЛДЭГ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ”-ээр шалгарууллаа.
- “Пи Эм Ай Монголия Чаптэр”-аас SocialPay 3.0 хувилбарын төслийг “ШИЛДЭГ ТӨСӨЛ”-өөр онцолж, өргөмжиллөө.
- SocialPay аппликейшн Азийн хамгийн том финтек фестиваль “Singapore Fintech Festival” -д оролцлоо.



## МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

- **Cobit5 IT Governance Framework:** Мэдээллийн технологийн Cobit5 засаглалын фреймворкийг банкны мэдээллийн технологийн үйл ажиллагаандаа нэвтрүүлж PWC-ээр аудит хийлгэж баталгаажууллаа.





## ЗЭЭЛ


**Корпорэйт:**  
**₮1.4 их наяд**

YTD %: +18%


**ЖДБ:**  
**₮1.2 их наяд**

YTD %: +28%

Зах зээлд эзлэх %



Голомтын зээлд эзлэх %




## ЭХ ҮҮСВЭР

**₮4.5 их наяд**


YTD %: +68%



Зах зээлд эзлэх %



Голомтын депозитод эзлэх %



## ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРТ

- “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл” хөтөлбөрийн хүрээнд 173 тэрбум төгрөгийн зээл олгосон нь нийт зах зээлд 21%-г эзэлж байна.
- Супермаркет, худалдааны төвийн барилгын санхүүжилтэд зориулж 100 тэрбум төгрөгийн зээл олгож **620 ажлын байр** бий болголоо.
- Худалдагчгүй дэлгүүр **Magic Store вендинг** машины төлбөр тооцоонд хамтран ажиллах, санхүүжилт олгох гэрээ байгуулав.
- “Сүлжээ дэлгүүрийн авлага барьцаалсан зээл”-н бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн ба 300 гаруй жижиг дунд аж ахуйн нэгжүүд сүлжээ дэлгүүрээс авах авлагаа барьцаалан эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх боломж бий боллоо.

**620**

Ажлын байр



## УУЛ УУРХАЙН САЛБАРТ

- Уул уурхайн томоохон компаниудад зориулж 148 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шинээр олгов.
- Оюутолгойн төсөлд туслан гүйцэтгэгч, бэлтгэн нийлүүлэгчээр ажиллаж буй харилцагч байгууллагуудад 2023 оны байдлаар 347 удаагийн 188 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт олгон ажиллалаа.
- Уул уурхайн түүхий эд материалын худалдан авалтад зориулж 7.0 сая ам.доллар буюу 24.1 тэрбум төгрөгтэй тэнцэх SWAP хэлцэл хийж харилцагчийг ханшийн эрсдэлээс хамгааллаа.

## ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

- МУ-ын банкны салбарыг тэргүүлэн санхүүжүүлсэн (CO2) ялгарлаа хэмжиж, UNEP FI Хариуцлагатай банкны зарчмын тайланд оруулан, Эрнст энд Янг аудитаар баталгаажуулан, тайлагнав;
- Хариуцлагатай банкны зарчмын дагуу уур амьсгал болон усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах дунд болон урт хугацааны зорилтоо тодорхойлов;
- МУ-ын Ерөнхийлөгчийн ивээл доор ToC холбооноос зохион байгуулсан “Тогтвортой санхүүжилтийн долоо хоног” олон улсын конвенцын эхний өдрийг буюу “Уур амьсгалын эрсдэлийн удирдлага” сэдэвт сургалтыг Голомт банк амжилттай зохион байгууллаа;
- Харилцагчдадаа зориулан Тогтвортой хөгжил, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн ганцаарчилсан сургалтууд зохион байгуулав.
- Харилцагчийн 1,177 зээлийн хүсэлтэд байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ хийж гүйцэтгэв.
- ToC холбооны “Жендерийн Манлай Байгууллага 2023”-аар шалгарав.


## НОГООН ЗЭЭЛ

- Банк ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор зээлийн бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэв. Нийт 5 төрлийн ногоон зээлийн санал болгож эхлэв.
- Эрчим хүчний хэмнэлттэй төсөл, хөтөлбөр болон ус, ариун цэврийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудад зориулан Global Climate Partnership Fund, WaterEquity нөлөөллийн сангуудтай хамтран зорилтот ногоон зээлийг олгож эхлэв.
- Ногоон зээлийн багц 2022 онд 95.8 тэрбум байсан бол **2023 онд 183.04 тэрбум** төгрөгт хүрч, нийт зээлийн багцын **4.0%**-д хүрлээ.

Scope 3 Financed  
emission 624,541  
tnCO2e



PCAF Partnership for  
Carbon Accounting  
Finance





## МУ-ЫН ЭКСПОРТ БОЛОН ДЭД БҮТЭЦ РҮҮ ЧИГЛЭСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДЭД ХАМТРАН АЖИЛЛАА

- Экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжихэд Голомт банк чухал үүрэгтэй оролцож, 2023 онд нийт **67 тэрбум** төгрөгийн уул уурхайн тоног төхөөрөмжийн аккредитив, **233 тэрбум** төгрөгийн нүүрсний экспортын аккредитивыг тус тус нээв.
- Монгол улсад хэрэгжиж буй дэд бүтэц, зам тээвэр, уул уурхай болон үйлдвэрийн бүтээн байгуулалтын төсөлд зориулж БНХАУ-ын Bank of China (**BoC**), Agricultural Bank of China (**ABOC**), Industrial and Commercial Bank of China (**ICBC**), Канад улсын Toronto Dominion Bank (**TD**) нартай хамтран тендер, урьдчилгаа төлбөр, гүйцэтгэл болон чанарын баталгаануудыг нээн ажиллаа.
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зарласан нийтийн тээврийн **600 автобус** нийлүүлэх тендерт зориулж БНХАУ-н Bank of China банктай хамтран дэлхийн нийтийн тээврийн шилдэг компанийн нэг болох **Yutong Bus Co., Ltd-н** нэрийн өмнөөс тендерийн, гүйцэтгэлийн болон чанарын баталгаануудыг амжилттай нээв.
- Харилцагчийнхаа барилгын үйлдвэрлэлд зориулан элс угаах үйлдвэрийн болон хаягдал ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж худалдан авах төсөлд дэмжлэг үзүүлж Итали улсын MPS банктай хамтран анх удаа урт хугацаат буюу **3 жилийн** хугацаатай баталгаажуулалттай аккредитивыг амжилттай нээв.



## ГАДААД ХАРИЛЦАА БОЛОН ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Олон Улсын Санхүүгийн Корпорац, Азийн Хөгжлийн Банкны гадаад худалдаа, нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн хөтөлбөрт гишүүн банкаар элсэн орж, нийт 30.0 сая ам.дол баталгааны шугамыг дахин сэргээв.
- ODDO BHF банканд ам.доллар болон еврогийн клирингийн данс, CaixaBank болон Crown Agents Bank банкуудад евро болон фунт стерлингийн данснудыг шинээр нээж харилцагчдын гүйлгээг саадгүй гүйцэтгэж байна. Ингэснээр Голомт банк нийт 49 корреспондент данс буюу хамгийн олон корреспондент дансны сүлжээтэй банк болов.
- Дэлхийд нэр хүндтэй, томоохон хөрөнгө оруулалтын сан, санхүүгийн байгууллагуудаас нийт 127.7 сая ам.долларын санхүүжилтийг бичил болон жижиг дунд бизнес эрхлэгч, тогтвортой, ногоон төслийг дэмжих зорилгоор татав.

## ТӨЛБӨР ТООЦООНЫ ЧИГЛЭЛЭЭР

- Swift ISO20022 стандартыг амжилттай нэвтрүүлж Свифтийн сүлжээгээр дамжуулан илгээх, хүлээн авах төлбөрийн мессежнүүдийг шинэ стандартад шилжүүлэв;
- Swift Pre-validation үйлчилгээ нэвтрүүлж, гадаад гүйлгээг илгээхээс өмнө хүлээн авагчийн дансны мэдээллийг шалгах боломжтой болов;



## ГАДААД КАСТОДИАНТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Гадаад кастодиан дах ностро дансаар дамжуулан харилцагч байгууллагуудад гадаад үнэт цаасны кастодианы үйлчилгээний боломжийг нэмэгдүүлсэнтэй холбоотой 100 сая орчим ам.долларын зах зээлийн үнэлгээ бүхий гадаад үнэт цаасны хадгалалт, төлбөр тооцоог гүйцэтгэж байна.

## КАСТОДИАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2023 онд нийт хадгалж буй хөрөнгийн хэмжээ 501 тэрбум төгрөгт хүрэв.
- Улаанбаатар үнэт цаасны биржтэй хамтран МУ-ын хөрөнгийн зах зээлд хамгийн анхны Хамтын биржээр арилжаалагддаг сангийн дэд бүтцийг нэвтрүүлэв.
- МУ-ын Хөрөнгийн зах зээлд 6 хамтын сан үйл ажиллагаа явуулж байгаагаас 5 хамтын санд үйлчилгээ үзүүлж хамтран ажиллаж байна.

J.P.Morgan



МАНДАЛ  
ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН



Мандал  
Хуримтлал





## ХАРИЛЦАГЧИЙН АРГА ХЭМЖЭЭ

- “Голомт Алтны Форум” арга хэмжээг 4 дэх удаагаа амжилттай зохион байгууллаа. Алт олборлогч топ аж ахуй нэгжээс гадна уул уурхайн машин механизм, тоног төхөөрөмж үйлдвэрлэгч, нийлүүлэгч 100 байгууллагын 300 орчим төлөөллийг хамруулан зах зээлд гарсан өөрчлөлт, ирээдүйн төлөв байдлыг хэлэлцлээ.
- Жил болгон зохион байгуулдаг FMC (Finance Managers Conference) болон Business conference арга хэмжээг “Think Globally, Act Locally” уриан дор 5 дахь жилдээ амжилттай зохион байгуулав.
- “Women owned” тохирлын тэмдэгтийг хэрэглээнд нэвтрүүлээ.



## ХАРИЛЦАГЧДАД МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨ ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа өргөжүүлж, бизнесээ дараагийн шатанд гаргахад нь зөвлөн дэмжих зорилгоор “Менторшип” хөтөлбөрийг 2 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлэв.
- Dua.golomtbank.com веб хуудас дээр нэмэлт хөгжүүлэлт хийгдэж, эдийн засаг хөрөнгө оруулалт, санхүүгийн салбарын чиглэлээр тогтмол контент хүргэхийн зэрэгцээ, илүү залуу үед хүргэх зорилгоор ДУА-гийн инстаграм хуудсыг нээн ажиллуулж эхэллээ.
- Eagle телевизтэй хамтран 13 удаагийн шинжээчийн цаг нэвтрүүлэгийг амжилттай бэлтгэсэн байна.



## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- Монголбанкны аргачлалаар чанаргүй зээлийн харьцаа 5.0%, эрсдэлийн сангийн хүрэлцээ 106.2% болж зээлийн багцын тоон болон чанарын зорилтоо бүрэн хангаж ажиллав
- Өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг олон улсын жишигт нийцүүлсэн (ICAAP, ILAAP)
- 2023 онд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Мэдээллийн аюулгүй байдлын ISO27001, Хувь хүний өгөгдөл хамгаалах хуулийн шаардлага (GDPR), Төлбөрийн картын аюулгүй байдлын PCI-DSS стандартуудын магадлан аудитыг амжилттай хийлгэсэн
- Банк цахим залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монголын Банкны Холбоо, Цагдаагийн Ерөнхий Газар, Монгол банктай хамтран “Цахим зөвлөмж” аяныг 2023 онд зохион байгуулсан
- Парисын Кибер орчин дахь аюулгүй байдлыг хангах харилцан итгэлцлийн уриалгад нэгдэв.





## ХҮНИЙ НӨӨЦ

- **“Ажилтан төвтэй банк”** бодлогын хүрээнд мэргэжлийн ёс зүйтэй, банкны үнэт зүйлд суурилсан, ажилтан бүрд ээлтэй хүний нөөцийн менежментийн тогтолцоог бий болгон урт хугацаанд, тогтвортой өсөж хөгжих боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Great place to work institute”-ээс **“Ажиллахад хамгийн таатай газар”** батламжийг Голомт банк 2022 онд Монгол Улсын банк, санхүүгийн салбараас анхлан авч байсан бол 2023 онд амжилтаа дахин бататгаж, уг батламжийг хоёр жил дараалан авсан анхны байгууллага боллоо.





 **ГОЛОМТ БАНК**  
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

# БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

Банк нь 2022-2023 онуудад чанаргүй зээлийн багцаа бууруулж, амжилттай IPO хийснээр **өөрийн хөрөнгө, ашигт ажиллагаагаа сайжруулж чадсан** билээ. Үүнд тулгуурлан банк 2024 он болон түүнээс цааших жилүүдэд **актив, орлогын хэмжээ, ашигт ажиллагааны өсөлтийг шинэ түвшинд хүргэж** салбартаа хоёр дахь том мөн ашигт ажиллагаагаараа хоёр дахь банк болох зорилтыг дэвшүүлж ажиллана. Бид 2024-2026 онд дундаж **өөрийн хөрөнгийн өгөөжийг 20%-аас дээш**, ногдол ашгийн хувьд банкны бизнесийн гүйцэтгэл, боломж, орчин, стратеги зэргийг харгалзан **хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг тогтвортой** байлгах зорилт тавьж байна.

2024 оны бизнес төлөвлөгөөний гол чиглэлүүд:

1. Дижиталчлалыг эрэлхийлэх
2. Зээлийн шийдвэр гаргалтын хурдыг нэмэгдүүлж, зээлийн удирдлагыг бэхжүүлэх
3. Шинэ зээлийн болон бусад бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх
4. ЖДҮ бизнес болон ритэйл бизнесээ бэхжүүлэх,
5. Тогтвортой санхүүжилтийг дэмжих
6. Урт хугацааны хөрөнгө босгох
7. Хөрөнгийн зах зээлд мэдээллийн ил тод харилцаа холбоог бий болгох




## БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ


Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12-р сарын 28-ны өдрийн ээлжит хурлын 00/35 тоот тогтоолоор 2024 оны 1-р сарын 15-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлэх Банкны бүтэц, зохион байгуулалт шинэчлэн батлагдлаа. Үүнд:

- **“Дижитал шилжилтийн газар”**-ыг шинээр байгуулах. Энэхүү газар нь Процесс удирдлагын хэлтэс, Дата удирдлагын хэлтэс, Төслийн удирдлагын хэлтэс гэсэн 3 хэлтэстэй байна.
- **“Харилцагчийн бүртгэлийн газар”**-ыг шинээр байгуулах. Энэхүү газар нь Зээлийн хувийн хэргийн хэлтэс, Харилцагчийн хувийн хэрэг хяналтын хэлтэс, Архив ложистикийн албатай байна.
- **“Зээл цуглуулах газар”**-ыг шинээр байгуулах. Энэхүү газар нь Утсаар цуглуулах хэлтэс, Биечлэн цуглуулах хэлтэс, Тусгай активын хэлтэс, Бүртгэлийн хэлтэс, Хөрөнгийн менежментийн албатай байна.
- **“Харилцагчийн үйлчилгээний газар”**-ыг шинээр байгуулах. Энэхүү газар нь Харилцагчийн үйлчилгээний хэлтэс, Харилцагчийн туршлагын хэлтэс, Гомдлын удирдлагын хэлтэстэй байна.
- “Зээлийн газар”-ын бүтцэд өөрчлөлт оруулж, “Бизнес процесс менежментийн газар”-ыг татан буулгав. Мөн хэлтэс, албадын түвшинд өөрчлөлтүүдийг оруулж бүтэц зохион байгуулалтыг шинэчлэв.

## 2024 ОНЫ АШГИЙН ЗОРИЛТ



## Цэвэр ашиг /тэрбум ₮/ болон Өөрийн хөрөнгийн өгөөж /%/



## НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТ, БОДЛОГО

| Ногдол ашиг төлөлт | 2023      | 2024*     |
|--------------------|-----------|-----------|
| Нэгж хувьцаанд     | 50₮       | 90₮       |
| Нийт ногдол ашиг   | 40.4 тб ₮ | 72.8 тб ₮ |

\*2023 оны ашгаас зарласан

- ТУЗ-ийн шийдвэрээр ногдол ашигт нэгж энгийн хувьцаанд 90 төгрөг, нийт 72.8 тэрбум төгрөг олгохоор шийдвэрлэв. Энэ нь МБ-ны тайлангаарх цэвэр ашгийн 40.3 хувьтай тэнцүү байна.
- Ногдол ашгийн бодлого: Бид банкны бизнесийн гүйцэтгэл, боломж, орчин, стратеги зэргийг харгалзан хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг тогтвортой байлгах бодлого барьж ажиллана.



 **ГОЛОМТ БАНК**  
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

---